



***ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН ТӨВД БАРИГДАХ АХМАДЫН
ӨРГӨӨНИЙ ГАДНА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ, ТОХИЖИЛТЫН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ***

Төслийн нэр: ***ИХХЭТ СУМЫН ТӨВД БАРИГДАХ АХМАДЫН
ӨРГӨӨНИЙ ГАДНА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ,
ТОХИЖИЛТЫН АЖИЛ***

Төслийн дугаар: ХА/2020/-02

Иххэт сум
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Иххэт сумын Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Иххэт сумын төвд баригдах ахмадын өргөөний гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000 /тавин мянган/төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө **Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2-р давхар 202 тоот** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 30 минутанд** Иххэт сумын ЗДТГ-н 3 давхар 304 тоот хурлын танхимд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тийм

Төлбөрийн хийх хэлбэр: Дансаар тушаана.

Банкны нэр: Төрийн сан банк

Дансны дугаар: 100060555406

Дансны нэр: До.Иххэт ЗДТГ н.с.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

***Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг даргын Тамгын газар
2-р давхар 202 тоот Засаг даргын орлогчийн өрөө
Утас: 95008997***


Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ: <ul style="list-style-type: none">(а) Үнийн санал;(б) Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/нотариатаар батлуулсан байна/(в) Шаардлагатай тусгай зөвшөөрөлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байна/ Тусгай зөвшөөрлийн ажилбарын заалт 2.1.1, 2.2.1, 2.2.2.(г) Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/(д) Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/(е) Шүүхийн тодорхойлолт /2018,2019 оны/(ё) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /2018,2019 оны/(ж) Харилцагч банкны тодорхойлолт /өр, зээлгүй байна/(з) Тендерт оролцогч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-р зүйлийн 1 дэх заалтын дагуу тухайн нөхцөл үүсээгүйг захиалагчид албан бичгээр мэдээлнэ.(и) 2018 он, 2019 оны санхүүгийн тайлан. Мөн тухайн онуудын санхүүгийн тайланд хийсэн аудиторын дүгнэлт(й) Тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар(к) Сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний хуулбар, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт(л) Тендерт оролцогчийн багаж, техник хэрэгслийн тодорхойлолт, ажлын байр, тоног төхөөрөмжийн жагсаалт(м) нийлүүлэх барааны загвар, тодорхойлолт, эсхүл гэрэл зураг, тэдгээрийн үнэн зөв болохыг гэрчилсэн баримт бичиг(н) барааны хувьд эрх бүхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээ, үйлдвэрлэлийн итгэмжлэл.(о) Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. угсралт, туршилт, тохируулгыг гүйцэтгэгч бүрэн хариуцна. Магадлашгүй ажлын зардал, зохиогчийн хяналтын зардлыг тусгах(ө) Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.(п) Сум орон нутгийн иргэдээс туслах ажилтан авч ажиллуулах нь давуу тал болно. |

- 4. Тендерийн үнэ**
- 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
- 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчтой гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал; 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/нотариатаар батлуулсан байна/ 3. Шаардлагатай тусгай зөвшөөрөлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байна/ 4. Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ 5. Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ 6. Шүүхийн тодорхойлолт /2018, 2019 оны/ 7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /2018, 2019 оны/ 8. Харилцагч банкны тодорхойлолт /өр, зээлгүй байна/ 9. Тендерт оролцогч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-р зүйлийн 1 дэх заалтын дагуу тухайн нөхцөл үүсээгүйг захиалагчид албан бичгээр мэдээлнэ. 10. 2018 он, 2019 оны санхүүгийн тайлан. Мөн тухайн онуудын санхүүгийн тайланд хийсэн аудиторын дүгнэлт 11. Тендерт оролцогчийн 2018, 2019 оны борлуулалтын орлого 80,000,000 /наян сая/ төгрөгөөс дээш байна. 12. Тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар 13. Сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт 14. Тендерт оролцогчийн багаж, техник хэрэгслийн тодорхойлолт, ажлын байр, тоног төхөөрөмжийн жагсаалт 15. Нийлүүлэх барааны загвар, техникийн тодорхойлолт, эсхүл гэрэл зураг, тэдгээрийн үнэн зөв болохыг гэрчилсэн баримт бичиг 16. Барааны хувьд эрх бүхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээ, үйлдвэрлэлийн итгэмжлэл. 17. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь 18. Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. угсралт, туршилт, тохируулгыг гүйцэтгэгч бүрэн хариуцна. Магадлашгүй ажлын зардал, техник хяналтын зардлыг тусгах. 19. Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. 20. Сум орон нутгийн иргэдээс туслах ажилтан авч ажиллуулах нь давуу тал болно. <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зөөврийн гагнуурын аппарат 2. Үйлчилгээний авто машин /ачааны/ 3. Бусад багаж техник хэрэгсэл
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Дорноговь аймгийн Иххэт сумын Зүлэгт баг Засаг даргын Тамгын газар Давхар болон өрөөний дугаар: 2-р давхар 202 тоот Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Дорноговь аймгийн Иххэт сумын Зүлэг баг Засаг даргын Тамгын газар Давхар болон өрөөний дугаар: 3 давхар 304 тоот хурлын танхим Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>


 БАТЛАВ
 ИХХЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
 /ш/ Г.НАМУУНЗУЛ/
 2020 оны 4 сарын 12 өдөр

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Шаардлага	Үзүүлэлт
1	Гадна дулаан, цэвэр усны ажил	<ul style="list-style-type: none"> ✓ Хангагч байгууллагуудаас олгогдсон техникийн нөхцлийн дагуу төвлөрсөн шугам сүлжээнд холбох ✓ Дулааны худгаас огтолцоо авч цутгамал бетон сувагт хийх ✓ Яндан хоолойг цэвэрлэж, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийн зориулалтын материалаар дулаалах ✓ Ус дамжуулах шугамын доод цэгт юүлэх, дээд цэгт хий авах хаалтыг угсрах, гулсах болон үл хөдлөх тулгуурыг зурагт зааснаар байрлуулах ✓ Цэвэр усны шугамыг цайрласан ган хоолойгоор дулааны шугамыг дагуулан хийх, сувагт дулаалгатай угсрах
2	Гадна бохир ус	<ul style="list-style-type: none"> ✓ Бохир усны сувагт элсэн дэвсгэр хийж, гадна зориулалтын хамгаалалттай хуванцар яндан хоолойгоор зурагт заасан налуутайгаар угсрах ✓ Бохир усны шугам нь дулаан цэвэр усны шугамтай огтлолцож байгаа хэсэгт гэр хоолой угсарч өгөх ✓ Бохир усны шугам нь хөдөлтийн гүнээс дээр байрлах тохиолдолд шугам хоолойг хөлдөхөөс хамгаалж дулаалах ✓ Шугамын трассын дагуу хөрсийг сайтар нягтруулж өгөх
3	Гадна цахилгаан	<ul style="list-style-type: none"> ✓ Ажлыг төсөвт тусгагдсан кабелиар барилгын норм дүрэм стандартын дагуу чанартай хийх ✓ Газардуулгыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх
4	Гадна тохижилт	<ul style="list-style-type: none"> ✓ Явган хүний замын дагуу хогийн сав, гэрэлтүүлэгтэй байх ✓ Явган хүний зам бат бөх, өнгө үзэмж сайтай байх ✓ Гадна талд өнгө үзэмжтэй зориулалтын сандал байрлуулах ✓ Гадна хашаа чанарын шаардлага хангасан орчин үед нийцсэн өнгө үзэмжтэй байх
5	Зохиогчийн хяналт	<ul style="list-style-type: none"> ✓ Төсвийн тооцоондоо зохиогчийн хяналтын ажлын зардал тусгасан байна.
6	Магадлашгүй ажлын зардал	<ul style="list-style-type: none"> ✓ Төсвийн тооцоондоо магадлашгүй ажлын зардал тусгасан байна.

Тав. Ажлын тоо, хэмжээ

Д/д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
01. Гадна дулааны ажил			
1	D=40мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	17
2	Дулааны сувгийн шуудууг механизмаар ухаж овоолох	м3	107.44
3	Сувгийн шуудууг гараар засч ухах	м3	3.32
4	Сувгийн уланд бетон дэвсгэр үе хийх БМ100	м3	7.8
5	150 мм хүртэл зузаантай сувгийн бетон хана цутах БМ150	м3	8.97
6	Сувагт ган яндан хоолой угсрах 40*3.5 мм	км	0.13
7	Хаалт голч d-40мм байрлуулах	ш	2
8	Ус буулгах вентиль угсрах голч d=25 мм	ш	2
9	Бетон дээр угсрах ОП-1 200*200*90	ш	48
10	Яндан хоолой усаар шахаж шалгах d=50 мм	м	130
11	Тусгаарлах гадаргууг хар лакаар будах	м2	24.1
12	Яндан хоолойд пенополиуретнаар дулаалга хийх	м2	41.3
13	Төмөр бетон сувгийн хавтан ГСХ-10	ш	83
14	Механизмаар шуудууг эргүүлж булах	м3	60.64
15	Шуудууг гараар эргүүлж булах, ухах	м3	9.10
02. Дулаан механик			
16	Ган яндан хоолой сувагт угсрах голч d=50мм	м	17
17	Халаалтын холих усны насос суурилуулах Н-6 метр, L-2.83м3/ц, Р=70вт	ш	1
18	Төмөр гэртэй термометр	ш	3
19	Гурвалсан крантай монометр	ш	4
20	Температур автомат тохируулах хаалт угсрах голч d=15мм	ш	1
21	Даралт автомат тохируулах хаалт угсрах голч d=15мм	ш	1
22	Бөмбөлгөн хаалт угсрах голч d=40мм	ш	4
23	Үл буцах хаалт угсрах голч d=40мм	ш	1
24	40мм хүртэл голчтой хог шүүгч тавих	ш	2
25	Отвод угсрах 90*С голч-40мм	ш	8
03. Гадна цэвэр усны ажил			
26	d=20мм голчтой ган хоолой угсрах	м	66
27	Бөмбөлгөн хаалт угсрах голч d=20мм	ш	1
28	Ус юүлэгч хаалт угсрах голч d=15мм	ш	1
29	Янданд чиг өөрчлөгч угсрах голч – 20мм	ш	8
30	Яндан хоолой усаар шахаж шалгах d=50мм	м	66
31	Тусгаарлах гадаргууг хар лакаар будах	м2	5.54
32	Яндан хоолойд пенополиуретанаар дулаалга хийх	м2	10.4
04. Гадна бохир усны ажил			
33	0.5м3 багтаамжтай шанагат эксковатороор шуудууг ухаж овоолох	м3	184.11
34	Шуудууг гараар засч ухах	м3	7.58
35	Элсэн дэвсгэр үе хийх	м3	1.5
36	Бохир усны хуванцар хоолой d=100	м	9
37	Бохир усны хуванцар хоолой d=100	м	102
38	Бохир ус дамжуулах угсармал бетон дугуй худаг D-	ш	4

	1000мм		
39	Бохир усны яндан хоолойд дулаалга хийх	м2	53.46
40	54/80 морины хүчтэй бульпозероор шуудууг шороогоор эргүүлж булах	м3	129.72
41	Шуудууг гараар шороогоор эргүүлж булах	м3	43.46
42	300 мм голчтой гэр хоолойг угсах	м	18
05. Гадна цахилгаан хангамж			
43	Кабелийн шуудуу гараар ухах	м3	49
44	Кабелийн доор элсэн дэвсгэр үе хийх	м	200
45	2кг хүртэл жинтэй кабелийг шуудуунд сунгах	м	400
46	Тоосгон хучилт кабельд хийх	м	200
47	35мм2 хүртэл огтлолтой кабелийн судсанд төгсгөвч шахах	ш	6
48	3 фазын электрон тоолуур угсах	ш	1
49	Шуудууг гараар эргүүлж булах	м3	20.4
06. Гадна тохижилт- Явган хүний замын ажил			
50	Талбайг механизмаар тэгшлэх	м2	60
51	Явган хүний замын суурийг элс-хайрганы хольцоор хийх	100м3	0.06
52	Явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх /1м2 талбайд орох хавтангийн тоо/	100м2	0.6
53	Явган замын хашлага угсах 0.5*0.3*0.15	100у/м	0.22
07. Гадна хашааны ажил			
54	Хуучин төмөр хашаанаас хэсэгчлэн буулгаж 2м өндөр төмөр шонтой 1.6 м төмөр сараалжин хашаа угсах	м	32
55	Төмөр хийцийн бэлдэц бэлтгэх	тн	0.83
56	Төмөр сараалжин хашаа хайс тосон будгаар 2 удаа будах	тн	0.83

Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

10. **Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. **Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. **Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. **Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. **Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. **Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. **Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
17. **Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Иххэт сумын төвд баригдах ахмадын өргөөний гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын угсралтын ажил: ХА/2020/-02
ГЕН 2.1	Ажлын талбай нь: <i>Дорноговь аймгийн Иххэт сумын Зүлэгт баг</i>
ГЕН 3.1	Төслийн менежер нь:
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: 2020.05.01 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: 2020.06.01
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>0,05хувь</i> байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>5 хувь</i> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>5 хоногийн</i> дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>3 хоногийн</i> дотор гаргаж өгнө.

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

